

#### 4.Үнэлгээний асуулга: “Шарын гол” ХК

Компанийн засаглалын үнэлгээний асуулга			
Кодексийн хэрэгжилтийг “Хэрэгжүүл, эсвэл тайлбарла” гэсэн зарчмын дагуу тайлагнах ба кодексийн зүйл тус бүрээр биелүүлсэн эсэх, биелүүлээгүй бол яагаад биелүүлээгүй, түүнийг орлох бутэц, зохион байгуулалтын арга хэмжээ авсан, эсхүл авч байгаа, хэрэв төлөвлөж буй бол хугацаатайгаар нь тайлбар хэсэгт тусгана..			
НЭГ. ТУЗ-ИЙН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг, туршлага, хараат бус байдал зэргийг зохистойгоор хангасан, алсын хараатай, бүтээлч, үр дүнтэй бүтэц байна			
№	Зүйл	Хэрэгжилт	Тайлбар
1	<b>1.1. Компани нь ТУЗ-ийн үйл ажиллагааны журнаар ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн даргын чиг үүрэг, хариуцлагыг нарийвчлан зохицуулна.</b>	Хэрэгжүүлсэн.	
2	<b>1.2. Компани нь ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, томилох асуудлыг тусгасан нэр дэвшиүүлэх журам, залгамж халааны бодлогын баримттай байна.</b>	КТХ-ийн дагуу зохицуулдаг байсан.	2022 оны 4 дүгээр улиралдаа багтаан журам, бодлогын бичиг баримттай болно.
3	<b>1.3. ТУЗ-ийн гишүүн бурийн ажлын туршлага, ажилласан хугацаа, хараат бус байдал, хувьцааны эзэмшилийн хувь хэмжээ, хуралдаанд оролцсон ирц зэрэг мэдээллийг жилийн үйл ажиллагааны тайландаа дэлгэрэнгүйгээр тусгаж, цахим хуудсандaa байршуулна.</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлсэн.	2022 оны жилийн үйл ажиллагааны тайлангаас эхлэн мэдээлэлийг бүрэн тусгаж ажиллана.
4	<b>1.4. Компани нь ТУЗ болон түүний дэргэдэх хороодын бүтэц, бүрэлдэхүүний бодлогын баримттай байх ба уг баримт бичигт гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг тусгана.</b>	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамтай.	ТУЗ гишүүний боловсрол, мэргэшил, ур чадвар, туршлагад тавигдах шаардлага болон хүйсийн тэнцвэрт байдал зэргийг ТУЗ-ийн үйл ажиллагааны журамдаа шинэчлэн тусгана.
5	<b>1.5. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулах ба ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ур чадвар, мэдлэг, мэдээллийг олгох, тэдгээрийгшинэчлэх сургалтад тогтолцоулж хамруулна.</b>	ТУЗ-ийн шинэ гишүүнийг холбогдох шаардлагатай мэдээлэлээр хангадаг.	
6	<b>1.6. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга нь ТУЗ-ийн үйл ажиллагааг зохистой явуулах асуудлаар ТУЗ-ийн даргаар дамжуулан хариуцлага хүлээнэ.</b>	ТУЗ-ийн үйл ажиллагааны журамын дагуу хариуцлага хүлээнэ.	
ДҮН			
ХОЁР. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ			
ТУЗ нь өөрийн үйл ажиллагааг тодорхой чиг үүрэг хариуцсан өөрийн дэргэдэх хороодоор дамжуулан хэрэгжүүлж, эцсийн хариуцлагыг хүлээнэ			
7	<b>2.1. ТУЗ-ийн дарга болоод ТУЗ-ийн гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.</b>	ТУЗ-ийн дарга нь хараат бус гишүүн байдаг.	КТХ-ийн 75 дугаар зүйлийн 75.4-т заасаны дагуу ТУЗ нь 9 гишүүнтэй 3/2 нь хараат бус гишүүн ажиллаж байна
8	<b>2.2. ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороо нь үйл ажиллагааны журам аудитын бодлогын баримт</b>	Хэсэгчлэн хэрэгжүүлдэг	2022 оны 4-р улиралд багтаан бодлогын

	<p>бичигтэй байна. Аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус байна. Аудитын хорооны хуралд компанийн гүйцэтгэх удирдлага болон ажилтнууд гагчхүү тус хорооны хүсэлтээр оролцно.</p>		баримт боловсруулан батлаж мөрдөнө.
9	<p>2.3. ТУЗ-ийн дэргэдэх цалин урамшууллын хороо нь цалин, урамшууллын үйл ажиллагааны журам, цалин урамшууллын бодлогын баримт бичигтэй байна. Цалин урамшууллын хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна. Цалин урамшууллын хорооны хуралд гүйцэтгэх удирдлага гагчхүү хорооны хүсэлтээр оролцно.</p>	Хэсэгчлэн хэрэгжүүлдэг	2022 оны 4-р улиралд багтаан бодлогын баримт бичгийг боловсруулан батлаж мөрдөнө.
10	<p>2.4. ТУЗ-ийн дэргэдэх нэр дэвишүүлэх хороо нь үйл ажиллагааны журам, залгамж халааны бодлогын баримт бичигтэй байна. Нэр дэвишүүлэх хорооны дарга нь ТУЗ-ийн дарга бус, мөн хараат бус гишүүн байна.</p>	Хэсэгчлэн хэрэгжүүлдэг	2022 оны 4-р улиралд багтаан бодлогын баримт бичгийг боловсруулан батлаж мөрдөнө.
11	<p>2.5. ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болно. ТУЗ-ийн дэргэдэх хороод бүгд үйл ажиллагааны журам, заавартай, чиг үүрээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг, ур чадвар, ажлын турилага бүхий бүрэлдэхүүнтэй байна.</p>	Хэсэгчлэн хэрэгжүүлдэг	ТУЗ нь өөрийн дэргэд бусад чиг үүрэг бүхий байнгын болон түр хороог байгуулж болохоор ТУЗ-ийн ажиллах журамд тусгасан. Харин хороодын үйл ажиллагааны журмыг шинээр 2022 оны 4-р улиралд багтаан батална.

ДҮН

#### ГУРАВ. ТАЙЛАГНАЛ, МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДАЛ

ТУЗ нь санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал, мэдээллийн ил тод байдлын үнэн, бүрэн, тэнцвэрт байдлыг хангана

12	<p>3.1. ТУЗ нь компанийн мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг баталж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p>	Хэрэгжүүлсэн	
13	<p>3.2. ТУЗ нь энэхүү кодекст заасан засаглалын баримт бичиг, дүрэм, журам, зааврыг цахим хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэнэ.</p>	Хэрэгжүүлэн ажиллана	2022 оны 3-р улиралд багтаан хэрэгжүүлэн ажиллана.
14	<p>3.3. Санхүүгийн болон санхүүгийн бус тайлагнал нь тэнцвэртэй, тодорхой, бодит байна. Санхүүгийн бус тайлан нь хүрээлэн буй орчин, нийгэм, эдийн засгийн хүрээнд компанийн тогтвортой үйл ажиллагаанд нөлөөлж болзошгүй хүчин зүйлс, эрсдэл, компанийн үйл ажиллагааны зорилго, зорилтууддаа хүрсэн эсэхийг үнэлсэн мэдээлэл байна.</p>	Хэрэгжүүлэн ажиллана	2022 оны жилийн эцсийн тайлангуудад тусгаж ажиллаж эхэлнэ.

ДҮН

#### ДӨРӨВ. АУДИТ, ХЯНАЛТЫН ТОГТОЛЦОО

ТУЗ нь аудит, хяналтын тогтолцооны хараат бус, үр дунтэй байдлыг хангана

15	<p>4.1. ТУЗ нь аудитын хорооны үйл ажиллагааны журамд хөндөнгийн аудитортой харьцах, түүнийг хуульд заасан чиг үүрээ саадгүй гүйцэтгэх нөхцөл боломжсоор хангах талаар тусгаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.</p>		ТУЗ-ийн үйл ажиллагааны журамдаа шинэчлэн тусгаж ажиллана.
16	<p>4.2. Хөндөнгийн аудитор нь хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож, аудиттай холбоотой асуудлаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгдөг байна.</p>		2023 оны ХЭ-ийн ээлжит хурлаас эхлэн хэрэгжүүлж эхэлнэ.
17	<p>4.3. Дотоод аудитын тогтолцоо, түүний бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, тэдгээрт орсон</p>		2022 оны жилийн үйл ажиллагааны

	<b>өөрчлөлтийн талаарх мэдээллийг компанийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар олон нийтэд тухай бүр мэдээлнэ.</b>		тайлангаар болон өөрчлөлт орсон тухай бүрд мэдээллэж ажиллана.
--	---	--	--

**ДҮН**

**ТАВ. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА**

**ТУЗ нь эрсдэлийн удирдлага болон комплайнсын хяналтыг зохистой байдлаар, хараат бусаар зохион байгуулж, тэдгээрийн үр дүнтэй байдалд тогтмол хяналт тавина**

18	<b>5.1. Компани нь эрсдэлийн удирдлагын заавар болон бүтэцтэй байх ба эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b>		Эрсдэлийн удирдлагын бодлогыг 2022 оны 4-р улиралд багтаан баталж ажиллана.
19	<b>5.2. ТУЗ нь дэргэдээ эрсдэлийн удирдлага хариуцсан хороотой байхыг зорих ба уг хороо нь гурваас доошигүй тооны гишүүнтэй, дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байна. Эрсдэлийн хорооны үйл ажиллагааны журам, бүтэц, бүрэлдэхүүнийг компанийн жилийн үйл ажиллагааны тайлан болон цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлж, тус хорооны хурлын ирц, хуралдсан асуудал, давтамжийн талаар тогтмол тайлagnana.</b>		Бодлогын баримт бичигтэй болсоноор хэрэгжүүлж эхэлнэ.
20	<b>5.3. Компанийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгмийн хариуцлага, эруул мэнд, аюулгүй байдлын эрсдэл байгаа эсэхийг үнэлэн нийтэд мэдээлж, тэдгээр эрсдэлийг хэрхэн удирдааж буйгаа тайлбарлана.</b>		Эдгээр асуудлаар эрсдэлийн үнэлгээ хийж 2022 оны жилийн үйл ажиллагаандaa тайлagnаж ажиллана.
21	<b>5.4. Компани нь комплайнсын хяналтын заавар болон бүтэцтэй байх ба комплайнсын хяналтын хэрэгжилтийн үр дүн, хараат бус байдалд ТУЗ хяналт тавина.</b>		Комплайнсын хяналтын заавар бүтцийг 2023 оны 1-р улиралд багтаан батална.

**ДҮН**

**ЗУРГАА. ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ЦАЛИН УРАМШУУЛАЛ**

**Эрх бүхий албан тушаалтны цалин, урамшууллын хэмжээ нь компанийн алсын хараа, онцлогт тохирсон, шударга, ил тод байна**

22	<b>6.1. ТУЗ-ийн гишүүний цалин, урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг хувьцаа эзэмшигчийн хурлаар ил тод хэлэлцэж батална.</b>	Хай би ойл ХК нь ТУЗ-дөө цалин урамшуулал олгодоггүй.	
23	<b>6.2. Компани цалин, урамшууллын хэмжээг тогтоох үндэслэл болсон ажил үргийн бүрдэл хэсгүүд, ажлын гүйцэтгэлийг үнэлэх шалгуурыг цалин, урамшууллын бодлогын баримтад тусгана.</b>		
24	<b>6.3. Компанийн жилийн үйл ажиллагааны тайландаа гүйцэтгэх удирдлагын үндсэн цалин, шагнал бусад урамшууллыг олгох гүйцэтгэлийн шалгуурыг тусгана.</b>		2022 оны жилийн үйл ажиллагааны тайландаа тусгаж ажиллана.

**ДҮН**

**ДОЛОО. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЭРХ АШИГ**

**Компанийн үйл ажиллагаанд оролцогч талуудын эрх ашгийг хүндэлнэ**

25	<b>7.1. Компани нь ТУЗ-өөс баталсан бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлогын баримт бичигтэй байна. ТУЗ болон гүйцэтгэх удирдлага нь оролцогч талуудын эрх ашгийг хүндэтгэн, тэдэнтэй хамтран ажиллах байгууллагын соёлыг төлөвшүүлнэ.</b>		
26	<b>7.2. Компанийн жилийн үйл ажиллагааны тайландаа оролцогч талуудтай хамтран ажиллахдаа ямар</b>		

	<i>асуудалд голчлон анхаарч, ямар стратеги баримтлан хэрхэн хэрэгжүүлжс ажилласан талаар тусгана.</i>		
27	<i>7.3. Оролцогч талуудтай хамтран ажиллах, мэдээлэл солилцох, харилцах зорилгоор компанийн цахим хуудсыг үр дүнтэйгээр ажиллуулна.</i>		
28	<i>7.4. Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдолыг хүлээн авч шийдвэрлэх дотоод журам, нийгмийн асуудлыг шийдэх, мэргэжил дээшилүүлэх дотоод журам, ажлын төлөвлөгөөтэй байна.</i>		

ДҮН

### НАЙМ. КОМПАНИЙН СОЁЛ

**ТУЗ-ийн гишүүд компанийд бизнесийн ёс зүйн өндөр хэм хэмжээг тогтоож, өөрсдөө манлайлан гүйцэтгэх удирдлага, ажилтнуудад мөрдлөг болгоно**

29	<i>8.1. Компанийн үнэт зүйлс, алсын харааг оновчтой тодорхойлжс, хууль ёсны, ёс зүйтэй, хариуцлагатай үйл ажиллагаа явуулах зорилгоор ТУЗ нь ёс зүйн дүрмийг батлан, нийтэд мэдээлжс, хэрэгжилтэд нь хяналт тавина.</i>	Гүйцэтгэх захирлын баталсан дүрэм журмаар зохицуулагддаг.	
30	<i>8.2. Аливаа хууль бус үйлдэл болон ёс зүйн зөрчлийг ТУЗ, эсвэл түүний дэргэдэх холбогдох хороонд мэдээлэх “шүгэл үлээгчийн” тогтолцоотой байна.</i>		Шүгэл үлээгчийн тогтолцоог холбогдох журамд 2022 оны 3-р улиралд багтаан тусгаж хэрэгжүүлнэ.
31	<i>8.3. Ёс зүйн дүрмээр авлига, албан тушаалын гэмт хэргээс ангид байх болон улс төрийн үйл ажиллагааг дэмжих, /дэмжихгүй байх/ хандив өргөх /өргөхгүй байх/ талаар зохицуулна.</i>		Ёс зүйн дүрмэнд тусгаж ажиллана.

ДҮН

### ЕС. ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ

**Компани болон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн эрхийг хүндэтгэн тэгш хандаж, мэдээлэл авах болон эрхээ хэрэгжүүлэх бололцоогоор бүрэн хангана**

32	<i>9.1. Компани оролцогч талуудад өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, засаглалын бүтэц, зохион байгуулалт, гүйцэтгэлийн үр дүнгийн талаарх мэдээллийг цахим хуудсаараа тухай бүр хүргэнэ.</i>	Жил, хагас жилийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайлангаар мэдээлэлийг хүргүүлдэг.	
33	<i>9.2. Компани хөрөнгө оруулагчидтай харилцах хөтөлбөртэй байх ба тэдэнтэй харилцах, мэдээлэл солилцох цахим сувгийг хөгжүүлнэ.</i>		Энэхүү цахим сувгийг 2023 оны 1-р улиралд багтаан хэрэгжүүлнэ.
34	<i>9.3. Компани хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал гаргах, санал өгөх, мэдээлэл авах зэрэг хууль ёсны эрхээ хэрэгжүүлэх бололцоо, нохцолийг бүрдүүлнэ.</i>	ХЭ-чид хууль ёсны эрхээ эдлэх нөхцөл, боломжоор хангагдсан.	
35	<i>9.4. Компанийн үйл ажиллагааны чиглэл, өмчлөлийн бүтцийн асуудлаар хувьцаа эзэмшигчдээс санал өгөх эрхээ хэрэгжүүлэхэд нь онцгойлон анхаарна.</i>	КТХ-ийн дагуу санал өгөх эрхээ хэрэгжүүлэх эрх нь нээлттэй байдаг.	
36	<i>9.5. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэх зорилгоор сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх журамтай байх ба хэрэгжилтийг нийтэд мэдээлнэ.</i>		Сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх тухай журмыг 2022 оны 4-р улиралд багтаан батална.

ДҮН

-оOo-